



Маягт 5- Gunston & Jefferson сургуулийн 8-р ангид суралцаж буй сурагчид

Энэхүү маягтыг Gunston & Jefferson дунд сургуулийн 8-р ангид сурдаг, 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн Washington-Liberty ахлах сургуульд дахин харъяалагдах нутаг дэвсгэрт амьдардаг сурагч -н эцэг эх/асран хамгаалагчид зориулан олгож байна.

Хэрэв хэд хэдэн хүүхэд нь 2022-23 оны хичээлийн жилийн дахин төлөвлөлтөд хамрагдсан байвал нэмэлт маягтуудыг ар гэрийнхэнд нь хүргүүлнэ.

АНС нь элсэлт багтаамжаас хэтэрч байгаа болон/эсвэл сүүлийн хоёр хичээлийн жилд элсэлт багтаамжаас хэтэрч байсан, ойрын сургууль нь нэмэлт сурагч авах багтаамжтай сургуулиудад 2021 оны Намрын улиралд харъяалал зохицуулах ажиллагааг хийж байгаа билээ.

АНС нь дараах [төлөвлөлтийн хэсгүүдийг](#) Wakefield ахлах сургуулиас Washington-Liberty ахлах сургуульруу хуваарилахаар төлөвлөж байна: 46110, 46120, 46111, 48160, 48180, 48290, 46140, 48150, 48280, 48281. **Энэхүү харъяаллын дахин төлөвлөлт нь одоо 8-р ангид суралцаж буй бүх сурагчид болон шинээр болон ирээдүйд элсэн орох бүх сурагчдад хамаарна.** Хоёр хэлний хөтөлбөрт хамрагддаг одоо 8-р ангид суралцаж буй сурагчид тухайн хөтөлбөртөө Wakefield дээр хамрагдах ба энэ өөрчлөлт нөлөөлөхгүй. Wakefield сургуульд одоо 9-11-р ангид сурч буй сурагчид Wakefield сургуульдаа суралцах эсвэл 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн (шинээр харъяалагдсан ахлах сургуульдаа) Washington-Liberty сургуульд суралцах боломжтой.

Энэхүү маягтын зорилго нь энэхүү харъяаллын дахин төлөвлөлтийн талаарх мэдээллийг таныг авсан болохыг баталгаажуулан одоо 8-р ангид сурч буй таны хүүхэд 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн Washington-Liberty ахлах сургуульд явж эхлэх болохыг мэдэгдэх юм.

Чөлөөлөгдөх эрх, Ах эгч дүү, Тээврийн мэдээлэл

- **Чөлөөлөгдөх:** Одоо Wakefield сургуульд 9-11-р ангид сурч буй сурагчдад энэхүү дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдөн Wakefield сургуульдаа 12-р ангиа төгстөл үргэлжлүүлэн суралцах эсвэл 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн шинээр харъяалагдсан (Washington-Liberty) сургуульд суралцах боломжийг олгох саналыг АНС-н ажилтнууд гаргаж байгаа.
- **Ах эгч дүү:** Дахин төлөвлөлтийн хэсэгт амьдардаг, одоо Wakefield сургуулийн 9-11-р ангид сурдаг сурагчийн дүү нар чөлөөлөгдөх эрхгүй ба ахлах сургуульд элсэхдээ (шинээр харъяалагдсан) Washington-Liberty сургуульд орно.
- **Тээвэр:** Одоо 8-р ангид сурч буй сурагчид 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн Washington-Liberty сургуульд элсэн ороход нь АНС-н тээврийн үйлчилгээг олгох ба дахин төлөвлөлтийн хэсэгт амьдардаг 9-11-р ангийн сурагчдад Gunston сургуульд үргэлжлүүлэн суралцах эсвэл (шинээр харъяалагдсан) Washington-Liberty сургуульд явах сонголт хийснээс үл хамааран үргэлжлүүлэн олгоно. Дахин төлөвлөлтийн хэсэгт амьдардаг, Wakefield сургуульд үргэлжлүүлэн суралцах 9-11-р ангийн сурагчдад сурагавтобусны [хаб зогсоолоор](#) дамжуулан тээврийн үйлчилгээ үзүүлнэ.

Хэрэв танд энэхүү маягтыг бөглөхөд туслалцаа хэрэгтэй бол apsboundaries@apsva.us хаягт имэйл бичих эсвэл Gunston эсвэл Jefferson сургуулийн оффист хандан хоёр хэлтэй ар гэртэй харилцагчтай уулзъя гээрэй.

Энэхүү үйл явцын талаарх нэмэлт мэдээллийг 2021 оны Намрын Харьяаллын дахин төлөвлөлтийн үйл явцын веб хуудас www.apsva.us/engage/fall-2021-boundary-process -аас авна уу.

1. Сурагчийн нэр _____
2. Сурагчийн овог _____
3. Сурагчийн дугаар _____
4. Сурагчийн одоо явж буй сургууль _____
5. Сурагч хэддүгээр ангид сурдаг _____
6. _____ Энэхүү харъяаллын дахин төлөвлөлтийн өөрчлөлтөөр манай 8-р ангид сурдаг хүүхэд 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн Washington-Liberty ахлах сургуульд явахыг би хүлээн зөвшөөрч байна.
7. Эцэг эх/асран хамгаалагчийн нэр _____
8. Өдөр холбогддох утас _____
9. Гар утас _____
10. Огноо _____